



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

3. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

4. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

My Doc./tushaal/.

1150300085




Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 03 сарын 28 өдрийн
14 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН
НЭРСИЙН ЖАГСААЛТ

2013.03.28

Улаанбаатар хот

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Өгөөмөр Алтай ХХК	Өгөөмөр Алтай	СонгиноХайрхан дүүрэг, 12-р хороо, Өнөр хорооллын 37/1 байр
2	Ундецим-Ундецим ХХК	Элеганс	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн гудамж 16/3 тоот
3	Ашид инж ХХК	Зочид буудал	Баянгол дүүрэг, 12-р хороо, 6-р бичил хороолол, Өргөө гудамж 7 тоот
4	Кондитер Улаанбаатар ХХК	Шинэ Алтай	СонгиноХайрхан дүүрэг, 18-р хороо, Энх тайвны өргөн чөлөө 28-р байр
5	Хаан палас ХХК	Кемпински хаан палас	Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө, Зүүн дөрвөн зам, 4-р хороо
7	ЭБ-3 ХХК	Амарбаясгалант	Сүхбаатар дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө, 15А/5
8	Дун өргөө ХХК	Өргөө	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж М-100-р байрны 6-р орц
9	Палас ХХК	Палас	Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 25 А
10	Сэлбэ плаза ХХК	УБ сити	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, То вангийн гудамж
11	Корпорейт хотел энд рэсорт нүхт ХХК	Корпорейт	Хан-Уул дүүрэг, 4-р хороо, Нүхтийн ам



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 03 сарын 29 өдрийн
14 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

2013.03.28

Улаанбаатар хот

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Б.Отгон	Мая хотел	Баянзүрх дүүргийн 25-р хороо, АОС 40 тоот.
2	"СББББ" ЗБНөхөрлөл	Оюу	Баянзүрх дүүргийн 16-р хороо, Дандарбалжирын гудамж, 10 тоот.
3	Цорсбуянт ХХК	Аеро	Хан-Уул дүүргийн, 10-р хороо, Морингийн зам
4	Нью жамп интернейшнл ХХК	Оргил	Хан-Уул дүүргийн, 11-р хороо, Оргил хотхон